



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журмыг нэгдүгээр, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулалтын газар (Б.Алимаа), Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв (Д.Мягмарсүх) нарт даалгасугай.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллагын бүртгэл, мэдээлэл, холбогдох бичиг баримтыг 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөр тасалбар болгон Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвд хүлээлгэн өгөхийг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв (Р.Чойноров)-д үүрэг болгосугай.

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журмын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны хуралд танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Баянмөнх)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.БАЯРСАЙХАН

0000000153

Хөдөлмөрийн сайдын 2016 оны  
02 дугаар сарын 05-ны өдрийн А/БЗ  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН  
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ШАЛГАЛТ АВАХ  
ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (цаашид “ХАБЭА” гэнэ) сургалт зохион байгуулах, шалгалт авах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлага, хэм хэмжээг мөрдөж хэрэгжүүлэх, ажил олгогч, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтныг эрүүл аюулгүй ажлын байрны орчинд ажиллуулах нөхцөлийг хангах, аюулгүй ажиллах мэдлэг, дадлага олгох, арга барилд сургах, аюул осолгүй ажиллах соёл, зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан этгээдэд ХАБЭА-н сургалт зохион байгуулахад энэ журам үйлчилнэ.

1.4. Ажил олгогч нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 17 дугаар зүйл, энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг холбогдох нэгж, ажилтан, зөвлөлөөр гүйцэтгүүлж, хяналт тавих ба гэрчилгээ авсан сургалтын байгууллагатай гэрээ байгуулан зохион байгуулж болно.

1.5. ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байгууллагын үйл ажиллагаанд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв, аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн газар, хэлтэс хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлага, чиглэлээр хангаж ажиллана.

Хоёр. ХАБЭА-н сургалт зохион байгуулах  
гэрчилгээ олгох

2.1. ХАБЭА-н сургалт зохион байгуулах төрийн болон төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1. Сургалтын анги танхимтай байх;

2.1.2. ХАБЭА-н чиглэлээр мэргэшсэн 3-аас доошгүй сургагч багш, арга зүйчтэй байх;

2.1.3. Сургалт зохион байгуулах техник хэрэгсэл, үзүүлэн таниулах материал, дадлагын газартай байх;

2.1.4. ХАБЭА-н сургалт зохион байгуулах үлгэрчилсэн хөтөлбөрийг үндэс болгон тухайн ажил мэргэжлийн аюулгүй ажиллагааны онцлогийг тусгасан сургалтын төлөвлөгөөтэй байх;

2.1.5. Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвтэй цахим хэлбэрээр холбогдон сургалтын мэдээ, тайлан өгөх нөхцөл бүрдүүлсэн байх;

2.1.6. Сургалтад хамрагдсан ажилтны зурагтай цахим бүртгэлийн мэдээлэл бүрдүүлэх боломжтой байх.

2.2. ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээ авах байгууллага нь Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвд дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ.

2.2.1. Гэрчилгээ авахыг хүссэн албан бичиг;

2.2.2. Энэ журмын 2.1.3, 2.1.5, 2.1.6-д заасан шаардлагыг хангасан талаар танилцуулга;

2.2.3. ХАБЭА-н сургалтын хөтөлбөр;

2.2.4. Сургалт явуулах багш арга зүйчдийн анкет, ХАБЭА-н чиглэлээр мэргэшсэн гэрчилгээ, сертификат;

2.2.5. Тухайн байгууллагын гэрчилгээ (нотариатаар батлуулсан байх);

2.2.6. ХАБЭА-н сургалтын төлбөрийн хэмжээ, холбогдох шийдвэр.

2.3. Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв нь тухайн байгууллагын ирүүлсэн материалыг судалж, холбогдох дүгнэлт санал боловсруулан Хөдөлмөрийн сайдын дэргэдэх ХАБЭА-н Үндэсний хорооны хуралд танилцуулна.

2.4. ХАБЭА-н үндэсний хорооны хуралд танилцуулсны үндсэн дээр Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвөөс ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээг 2 хүртэл жилийн хугацаатай олгоно.

2.5. ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд тухайн байгууллага хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө гэрчилгээг сунгуулах хүсэлт, үйл ажиллагааны тайлангаа Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвд ирүүлнэ. Тус төв байгууллагын хүсэлт, үйл ажиллагааны үр дүнг судлан, дүгнэлт саналаа ХАБЭА-н Үндэсний хорооны хуралд танилцуулж, гэрчилгээг энэ журмын 2.4-д заасан хугацаагаар сунгана.

2.6. ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээний загварыг Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв батална. Гэрчилгээнд олгосон огноо, хүчинтэй байх хугацаа, ХАБЭА-н сургалтын төрөл, сургалт зохион байгуулах байгууллагын шаардлагатай мэдээлэл зэргийг оруулна.

2.7. ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байгууллага сургалтын хөтөлбөрийн агуулга хангахгүй, хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцээгүй, хяналт-үнэлгээгээр хангалтгүй дүгнэгдсэн, эсхүл ажил олгогч, иргэдээс гомдол ирүүлсэн тохиолдолд сургалт зохион байгуулах гэрчилгээг цуцлах, түдгэлзүүлэх асуудлын талаар Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв саналаа ХАБЭА-н Үндэсний хорооны хуралд танилцуулж шийдвэрлэнэ.

2.8. ХАБЭА-н сургалтыг стандарт шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй, гэрчилгээ аваагүй байгууллага болон гэрчилгээний хугацаа дууссан

байгууллага сургалт явуулсан тохиолдолд Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хууль тогтоомжид заасан эрхийн дагуу арга хэмжээ авна.

2.9. ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байгууллага нь Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвөөс батлан гаргасан маягтын дагуу зохион байгуулсан сургалт, хамрагдсан ажилтны талаарх болон холбогдох улирал бүр гаргаж дараа сарын 5-ны дотор тус төвд ирүүлнэ.

#### Гурав. ХАБЭА-н сургалтын зохион байгуулалт

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, чанар хэрэгжилтэд хяналт тавих ажлыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, ажил олгогч шууд хариуцна.

3.2. Хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч иргэн, малчид, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөлийн ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс хариуцан сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байгууллагатай хамтран зохион байгуулна.

#### Дөрөв. ХАБЭА-н сургалтын төрөл, хэлбэр

4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь дараах төрөлтэй байна:

4.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, эздийн;

4.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх;

4.1.3. Нийт ажилтны;

4.1.4. Ажилд шинээр орж байгаа ажилтны;

4.1.5. Өөр ажлын байранд шилжсэн ажилтны;

4.1.6. Өргөх, зөөх тээвэрлэх механизмтэй харьцаж ажилладаг ажилтны;

4.1.7. Цацрагийн үүсгүүртэй харьцаж ажилладаг ажилтны;

4.1.8. Химийн хорт бодис хэрэглэж байгаа ажилтны;

4.1.9. Даралтад сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтны.

4.2. Шинээр болон өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалтыг нарийн мэргэжилтэй ажилтан, цех, хэсгийн дарга, даамал, талбайн инженер, мастерын удирдлагын дор зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд ХАБЭА-н сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байгууллагатай хамтран явуулж болно.

#### Тав. Шалгалт авах журам

5.1. Нийт ажилтны болон ажилд шинээр орсон, өөр ажлын байранд шилжиж ажилласан ажилтны сургалтад хамрагдсан ажилтнаас шалгалт авч сургалтад хамрагдсан ажилтны нэрсийн жагсаалт гаргаж, ажилтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

5.2. Хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, малчид, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөлийн ажилтнуудын ХАБЭА-н сургалтад хамрагдсан иргэдээс

аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, сургалт зохион байгуулсан байгууллагатай хамтран зохион байгуулж сертификат олгоно.

5.3. Энэ журмын 4.1.2, 4.1.6-4.1.9-д заасан сургалтад хамрагдаж, шалгалтанд тэнцсэн ажилтанд сургалт зохион байгуулсан байгууллага сертификат олгоно. Сертификатын ард хөтөлбөрийн сэдэв, цагийг бичсэн байна.

5.4. ХАБЭА-н сургалтад хамрагдсан ажилтнуудаас авах шалгалтыг ярилцлага, дадлага, тест, бусад хэлбэрээр зохион байгуулна. Шалгалтанд тэнцээгүй ажилтнаар тухайн ажлын байранд ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

5.5. Сургалтад хамрагдсан боловч шалгалтанд тэнцээгүй тохиолдолд давтан сургасны дараа дахин шалгалт авч болно.

#### Зургаа. ХАБЭА-н сургалтын санхүүжилт

6.1. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулахад шаардлагатай байр, техник хэрэгсэл, сургалтын материал бусад шаардлагатай зардлыг "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай" хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.1-д заасны дагуу санхүүжүүлнэ.

6.2. Хувиараа, албан бусаар хөдөлмөр эрхлэгч, малчид, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөлийн ажилтнуудын ХАБЭА-н сургалтын зардлыг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсөвт тусгах замаар шийдвэрлэж болно.

----ООО----

Хөдөлмөрийн сайдын 2016 оны  
02 дугаар сарын 05-ны өдрийн А/33  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН  
СУРГАЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

Нэг. Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эздийн сургалтын  
үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Хөдөлмөрийн тухай хууль	1 цаг
ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандартын тухай	1 цаг
ХАБЭА-н менежментийн систем, OHSAS 18001 стандартын тухай	1 цаг
Хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудал	1 цаг
Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	1 цаг
Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хяналт тогтоох, урьдчилан сэргийлэх арга замын талаар	1 цаг
ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журмын талаар	1 цаг
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогыг шалтгаан, бууруулах арга зам /ҮОХХСБ дүрэм/	1 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	8 цаг

Хоёр. Нийт ажилтны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Хөдөлмөрийн тухай хууль	2 цаг
ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандарт	2 цаг
ХАБЭА-н менежмент системийн тухай	1 цаг

Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хяналт тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах чадвар эзэмших	1 цаг
Хөдөлмөрийн эрүүл ахуй түүнд тавигдах шаардлага	1 цаг
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын шалтгаан, урьдчилан сэргийлэх арга зам	1 цаг
Цахилгаан, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	1 цаг
Хөдөлмөрийн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах нь	1 цаг
Осолд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж	1 цаг
Галын аюулгүй ажиллагаа	1 цаг
Онцгой үед аврах арга хэмжээ, гамшгаас урьдчилан сэргийлэх	1 цаг
Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйлийг иргэдэд төлөвшүүлэх	1 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	14 цаг

Гурав. Ажилд шинээр орж байгаа иргэн, ажилтны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Тухайн ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааварчилгаа	1 цаг
Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, түүнийг ашиглах, тогтмол хэрэглэж хэвшүүлэх	1 цаг
Байгууллагын дотоод журам	1 цаг
Хөдөлмөрийн болон хамтын гэрээ	1 цаг
Ажлын байранд галын аюулгүй байдлыг хангах	1 цаг
Аюулыг танин мэдэх, илрүүлэх, мэдээлэх, арилгах	1 цаг
Ажлын байранд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	1 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	7 цаг

Дөрөв. Өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалтын  
үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Тухайн ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааварчилгаа	1 цаг
Тухайн ажлын байрны эрсдэлийн тухай	1 цаг
Тухайн ажлын байранд шаардагдах ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, түүнийг ашиглах, тогтмол хэрэглэж хэвшүүлэх	1 цаг
Тухайн ажлын байрны технологийн горимын талаар	1 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	4 цаг

Тав. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтныг мэргэшүүлэх  
сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Хөдөлмөрийн тухай хууль	4 цаг
ХАБЭА-н тухай хууль	4 цаг
ХАБЭА-н менежментийн систем	2 цаг
Хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн эрүүл ахуй	2 цаг
ХАБЭА-н удирдлагын тогтолцоо-шаардлага OHSAS 18001 стандарт	2 цаг
Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	2 цаг
Цахилгаан, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	2 цаг
Даралтат сав, шугам хоолой, өргөн тээвэрлэх машин механизмын аюулгүй ажиллагаа	2 цаг
Аж ахуйн нэгж, байгууллага дээрх ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах журам	2 цаг
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын шалтгаан, түүнийг бууруулах арга хэмжээ	1 цаг



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм	4 цаг
Галын аюулгүй байдлын тухай хууль	1 цаг
Гамшгаас хамгаалах тухай хууль	1 цаг
Онцгой байдлын үед ажиллах журам	2 цаг
Осолдогсдод үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж	3 цаг
Дадлага, группээр ажиллах	6 цаг
Шалгалт, үнэлгээ	
НИЙТ	40 цаг

Зургаа. Өргөх, зөөх тээвэрлэх механизм /ӨЗТМ/-тай харьцаж ажилладаг ХАБЭА-н ажилтны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
ӨЗТМ-ын нэр төрөл, бүтэц зохион байгуулалт, онцлогууд	2 цаг
ӨЗТМ-ын аваар ослоос хамгаалах хэрэгслүүд тэдгээрт тавих хяналт	2 цаг
Оосорлох хэрэгслүүд, тэдгээрт тавигдах шаардлага, хяналт	1 цаг
Үйлдвэрлэлд ӨЗТМ ашиглах үеийн аюулгүй хүчин зүйлүүд, эрсдэлийн үнэлгээ	2 цаг
ӨЗТМ-ын аюулгүй ажиллагаа хариуцагчийн үүрэг, техник зохион байгуулалт, засвар угсралт	2 цаг
ӨЗТМ-ын цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа	1 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	10 цаг

Долоо. Цацрагийн үүсгүүртэй харьцаж ажилладаг ажилтны ХАБЭА-н үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль эрх зүйн үндэс	1 цаг

Цацраг идэвхт чанарын тухай ерөнхий ойлголт	2 цаг
Цацрагийн шаардлага, тун, тунгийн хязгаар	1 цаг
Цацрагийн үүсгүүртэй харьцах үед тавигдах аюулгүйн шаардлага	2 цаг
Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа	2 цаг
Цацрагийн ослоос сэргийлэх нь	2 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	10 цаг

Найм. Химийн хорт бодис хэрэглэж байгаа ажилтны ХАБЭА-н сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж	2 цаг
Химийн бодисын тухай орчин үеийн ойлголт, ангилал	1 цаг
Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл, хадгалалт, тээвэрлэлт, шошгожуулалтын менежмент	1 цаг
Олон улсын химийн барааны CAS	1 цаг
Хор аюулын тухай лавлах мэдээлэл /ХАЛМ/, түүний ашиглалт, хяналт	1 цаг
Химийн ба биологийн бодисын аюулгүй ажиллагаа	1 цаг
Химийн ба биологийн хортой бодисоор хордсон үед үзүүлэх анхны тусламж	1 цаг
Химийн ба биологийн бодисын аюулгүй ажиллагаанд хэрэглэгдэх хамгаалах хэрэгсэл	1 цаг
Химийн бодисын менежментийн шинэ програм	1 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	10 цаг

Ес. Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтны ХАБЭА-н сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Сэдвийн нэр	Агуулгын багтаамж
Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм	2 цаг
Уур халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм	2 цаг
Баллонд тавигдах шаардлага, аюулгүй ажиллагаа	2 цаг
Даралтат савны гагнуур, дулааны боловсруулалтын аюулгүй ажиллагаа	2 цаг
Шалгалт, үнэлгээ	
Нийт	8 цаг

---oOo---